

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ  
ХЯНАЛТЫН СУУРЬ  
КОНВЕНЦ




6 дугаар зүйлийг  
хэрэгжүүлэх  
Удирдамж



**FCTC**

WHO FRAMEWORK CONVENTION  
ON TOBACCO CONTROL



## ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:

“Тамхины эрэлтийг бууруулахад  
чиглэсэн үнэ ба татварын арга  
ХЭМЖЭЭ”

Оролцогч талуудын Бага хурлын зургаадугаар (шийдвэр дугаар FCTC/COP6(5))  
хуралдаанаар баталсан

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/price-and-tax-measures-to-reduce-the-demand-for-tobacco>

## **ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 6 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ**

### **ТАМХИНЫ ЭРЭЛТИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ҮНЭ БА ТАТВАРЫН АРГА ХЭМЖЭЭ**

#### **1. ТАНИЛЦУУЛГА**

##### **Удирдамжийн зорилго**

Энэхүү удирдамж нь ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (ДЭМБ-ын ТХСК)-ийн бусад зүйл, заалт болон Оролцогч талуудын Бага хурлын шийдвэрүүдтэй нийцүүлэн тус конвенцийн 8 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Оролцогч талуудад туслах зорилготой. Удирдамжийг тамхины хэрэглээг бууруулахад чиглэсэн үнэ болон татварын үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлсэн Оролцогч талуудын туршлага дээр үндэслэн боловсруулсан болно.

##### **Үндсэн зарчим**

Тамхины хэрэглээ нийгэмд бүхэлд нь эдийн засгийн ихээхэн дарамт учруулдаг. Тамхины хэрэглээний сөрөг халих шинж нь тамхинаас шалтгаалсан өвчлөлтэй холбоотой эрүүл мэндийн шууд зардал, эдгээрийн улмаас хөдөлмөрийн чадвар алдах, бүтээмж буурах, цаг бусаар нас барахтай холбоотой шууд бус зардлаар илэрдэг.

Тамхинд ногдуулах татварыг оновчтой тогтоосноор тамхины хэрэглээг бууруулахын зэрэгцээ түүнтэй холбоотой эрүүл мэндийн зардлыг багасгах боломжтой.

Татварын болон үнийн бодлого нь тамхин бүтээгдэхүүний эрэлт, хэрэглээнд нөлөөлдөг хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм. Тийм ч учраас ДЭМБ-ын ТХСК-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх нь тамхины хяналтын бодлого, нийгмийн эрүүл мэндийг бэхжүүлэх хүчин чармайлтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болдог. Тамхинд ногдуулах татварын бодлогыг ДЭМБ-ын ТХСК-д нийцсэн тамхины хяналтын цогц стратегийн нэг хэсэг болгон хэрэгжүүлэх шаардлагатай.

ДЭМБ-ын ТХСК-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

##### **1.1 Тамхинд ногдуулах татварын бодлогыг тодорхойлох нь Оролцогч талуудын бүрэн эрх.**

ДЭМБ-ын ТХСК-ийн 6.2 дахь хэсэгт заасан ёсоор Оролцогч талуудын өөрийн татварын бодлогыг тодорхойлох, татварын хэмжээг тогтоох бүрэн эрхтэй бөгөөд энэхүү удирдамж нь бүхэлдээ уг бүрэн эрхийг хүндэтгэн үзсэн болно.

##### **1.2 Тамхинд ногдуулах татварыг оновчтой тогтоох нь тамхины хэрэглээг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулдаг.**

Тамхин бүтээгдэхүүнд ногдуулах татварыг (инфляцийн түвшинг харгалзан) хэрэглээний бодит үнийг нэмэгдүүлэхүйц хэмжээнд тогтоосноор тамхины

хэрэглээг багасгаж, улмаар өвчлөл, нас баралтыг бууруулж, хүн амын эрүүл мэндийг сайжруулах боломжтой. Тамхины татварыг нэмэгдүүлэх нь хүүхэд залуучуудыг тамхинд орохоос хамгаалах, тамхинаас гарахад нэн чухал ач холбогдолтой арга юм.

### **1.3 Тамхины татвар нь орлогын чухал эх үүсвэр болдог.**

Тамхины татварыг оновчтой тогтоох нь улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд ач холбогдолтой. Татварын өсөлт нь тамхины хэрэглээний бууралтаас их байдаг тул татварыг нэмэх нь төсвийн орлогын өсөлтөд хүргэдэг.

### **1.4 Тамхины татвар нэмэгдүүлэх нь нь эдийн засгийн үр ашигтай бөгөөд эрүүл мэндийн тэгш бус байдлыг багасгадаг.**

Тамхины эрэлт мэдрэг бус учраас түүнд ногдуулах татвар нь эдийн засгийн хувьд үр ашигтай байдаг. Бага ба дунд орлоготой хүн амын бүлгүүд татвар, үнийн өсөлтөд харьцангуй мэдрэг байдаг тул орлого ихтэй хүн амын бүлэгтэй харьцуулахад энэ бүлгийн хүн амд тамхины хэрэглээ илүүтэй буурч, улмаар эрүүл мэндийн тэгш бус байдал, тамхитай холбоотой ядуурал багасдаг.

### **1.5 Тамхины татварын тогтолцоо болон удирдлага нь үр дүнтэй, үр ашигтай байх ёстой.**

Тамхины татварын тогтолцооны бүтэц, зохион байгуулалт нь татвар хураах болон захиргааны зардлыг аль болох бага түвшинд байлгахын зэрэгцээ татварын орлогыг зохих түвшинд хүргэж, эрүүл мэндийн зорилтыг хангахуйц байвал зохино.

Тамхины татварын тогтолцоог үр ашигтай, үр дүнтэй удирдах нь татвар төлөлт, татварын орлогын бүрдүүлэлтийг сайжруулж, татвар төлөхөөс зайлсхийх явдал болон тамхины хууль бус худалдааг багасгадаг.

### **1.6 Тамхины татварын бодлогыг тамхи үйлдвэрлэгчийн уламжлалт ашиг сонирхлоос хамгаалах шаардлагатай.**

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын нэг хэсэг болох тамхины татварын болон үнийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг ДЭМБ-ын ТХСК-ийн 5.3 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэх удирдамжид заасан ёсоор тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхол, тухайлбал татварын болон үнийн бодлогын хэрэгжилтийг саатуулах зорилгоор хууль бус худалдааны асуудлыг ашиглах тактик, мөн аливаа ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах шаардлагатай.

## **Удирдамжийн хамрах хүрээ**

Энэхүү удирдамж нь тамхин бүтээгдэхүүний үнийг бусад бараа, үйлчилгээний үнээс илүүтэй нэмэгдүүлэх үндсэн арга болсон тамхины онцгой албан татварын асуудалд анхаарсан болно. Харин орлогын албан татвар, олон нийтийн хураамж, хөрөнгө оруулалтыг дэмжих хөнгөлөлт зэргийг энд авч үзээгүй. Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), импортын татварын талаар 3.1.5 дугаар хэсэгт товч авч үзсэн байна.

Тамхины татварын бодлого нь тамхин бүтээгдэхүүний хэрэглээний үнэд нөлөөлж, улмаар уг бүтээгдэхүүнийг худалдан авах чадвар, хэрэглээг бууруулж чаддаг. Гэхдээ тамхины татварын бодлогыг ДЭМБ-ын ТХСК-тай нийцүүлэн хэрэгжүүлэх бусад бодлогын хамтаар тамхины хяналтын цогц стратегийн нэг

хэсэг болгон хэрэгжүүлэх нь зүйтэй. Ингэхдээ татвар, үнийн бодлого болон орлогын өсөлтийн хоорондын харилцан хамаарал зэрэг эдийн засгийн бодлогын өргөн хүрээний асуудал, хүн амд үзүүлэх нийгмийн нөлөө зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Гэвч ийм төрлийн дүн шинжилгээ энэхүү удирдамжийн хамрах хүрээнээс хальсан асуудал юм.

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны асуудлыг ДЭМБ-ын ТХСК-ийн 15 дугаар зүйл болон Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протоколд авч үзсэн болно. Цөөнгүй Оролцогч талууд тамхины татварыг нэмж, ашиг орлогоо өсгөж чадсан бөгөөд үүний улмаас тамхины хууль бус худалдаа нэмэгдээгүй байна. Хууль бус худалдааг хязгаарлах нь татвар, үнийн бодлогын тамхины хэрэглээг бууруулах, нийгмийн эрүүл мэндийг сайжруулах үр нөлөөг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

## Нэр томъёоны тайлбар

Энэхүү удирдамжид хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

**“Бодит”** гэж инфляцийн тохируулга хийснийг;

**“Бүтээгдэхүүнийг орлуулах”** гэж үнийн өөрчлөлт буюу бусад хүчин зүйлтэй холбоотойгоор нэг тамхин бүтээгдэхүүний хэрэглээнээс нөгөөд, тухайлбал янжуур тамхинаас дүнсэн тамхины хэрэглээнд шилжихийг;

**“Жижиглэн худалдааны үнэд онцгой албан татварын эзлэх хувь”** гэж холбогдох бүх татварыг багтаасан тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдааны үнэд түүнд ногдуулах онцгой албан татварын эзлэх хувийг;

**“Жижиглэн худалдааны үнэд татварын эзлэх хувь”** гэж холбогдох бүх татварыг багтаасан тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдааны үнэд түүнд ногдуулах бүх төрлийн татварын эзлэх хувийг;

**“Жинлэсэн дундаж үнэ”** гэж тамхин бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн үнийг борлуулалтынх нь хэмжээгээр жинлэх замаар тооцсон тамхин бүтээгдэхүүний дундаж үнийг;

**“Импортын татвар”** гэж тамхин бүтээгдэхүүн зэрэг зарим тодорхой нэр төрлийн импортын бүтээгдэхүүнд ногдуулдаг татварыг;

**“Нэгдсэн татвар”** гэж тодорхой бараа бүтээгдэхүүний бүх төрөл (ж.нь, янжуур тамхины бүх брэнд)-д ижил хувь хэмжээгээр ногдуулдаг татварыг;

**“Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)”** гэж үйлдвэрлэл буюу түгээлтийн дамжлага тус бүр дээр нэмэгдсэн өртөгт тулгуурлан олон төрлийн (дотоодын ба импортын) бүтээгдэхүүнд ногдуулдаг татварыг;

**“Онцгой албан татвар”** гэж тамхин бүтээгдэхүүн зэрэг зарим тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд ногдуулдаг татварыг;

**“Орлоготой холбоотой эрэлтийн мэдрэмж”** гэж бодит орлого нэг хувиар нэмэгдэхэд хэрэглээнд гарч буй өөрчлөлтийн хувийг;

**“Өртөгт суурилсан(ад валорем) онцгой албан татвар”** гэж жижиглэн худалдааны үнэ, үйлдвэрлэгчийн үнэ эсхүл өртөг, даатгал болон тээврийн зардал зэрэг өртөгт тулгуурлан сонгосон бараа бүтээгдэхүүнд ногдуулдаг татварыг;

**“Сөрөг халих шинж”** гэж хэрэглэгч бус этгээдэд учирч буй зардлыг;

**“Тархалт”** гэж тамхин бүтээгдэхүүн хэрэглэж буй хүн амын эзлэх хувийг;

**“Тусгай онцгой албан татвар”** гэж тодорхой бүтээгдэхүүний тоо хэмжээ, тухайлбал янжуур тамхины тоо ширхэг, дүнсэн тамхины жинд тулгуурлан ногдуулдаг татварыг;

**“Үнэтэй холбоотой эрэлтийн мэдрэмж”** гэж бодит үнэ нэг хувиар нэмэгдэхэд хэрэглээнд гарч буй өөрчлөлтийн хувийг;

**“Хил дамнасан худалдан авалт”** гэж тамхин бүтээгдэхүүний татвар буюу үнэ харьцангуй өндөр байдаг нутаг дэвсгэрт хэрэглэх зорилгоор татвар буюу үнэ багатай нутаг дэвсгэрээс тамхин бүтээгдэхүүн худалдан авахыг;

**“Холимог татвар”** гэж тусгай татвар болон өртөгт суурилсан (ад валорем) татварын аль алийг хослуулсан татварыг;

**“Худалдааны татвар”** гэж жижиглэн худалдааны үнэд тулгуурлан олон төрлийн бүтээгдэхүүнд ногдуулдаг татварыг;

**“Худалдан авах чадвар”** гэж нэг хүнд ногдох орлоготой харьцуулсан үнэ;

**“Хэрэглээ”** гэж нийт хэрэглэсэн тамхин бүтээгдэхүүний абсолют хэмжээг;

**“Шаглах”** гэж татвар буюу үнэ багатай газраас тамхин бүтээгдэхүүн худалдан авч, илүү өндөр татвар буюу үнэтэй газарт дахин борлуулахыг;

**“Шаталсан татвар”** гэж үнэ, шинж чанар, үйлдвэрлэлийн онцлог зэрэг хүчин зүйлсийг харгалзан тодорхой бараа бүтээгдэхүүний өөр өөр төрөлд ялгавартай хувь хэмжээгээр ногдуулдаг татварыг.

## **2. ТАМХИНЫ ТАТВАР, ҮНЭ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХООРОНДЫН ХАМААРАЛ**

Татвар бол бодлого боловсруулагчдын зүгээс тамхин бүтээгдэхүүний үнэд нөлөөлөх үр дүнтэй арга хэрэгсэл юм. Ихэнх тохиолдолд тамхин бүтээгдэхүүнд өндөр татвар ногдуулах нь бүтээгдэхүүний үнэ өсч, улмаар тамхины хэрэглээ болон тархалт, тамхины шалтгаант өвчлөл, эндэгдэл буурч, хүн амын эрүүл мэнд сайжрахад хүргэдэг. Тамхины үнэ болон хэрэглээ хоорондоо урвуу хамааралтай болохыг олон судалгаагаар баталсан нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн байна.

### **2.1 Үнэ ба хэрэглээ/тархалтын хоорондын хамаарал (үнэтэй холбоотой мэдрэмж)**

Татвар болон үнэ нь тамхин бүтээгдэхүүний хэрэглээ, тархалтын аль алинд нь нөлөөлдөг. Дэлхий нийтийн нотолгооноос харахад тамхин бүтээгдэхүүний үнэ нь тархалт болон нэг тамхичны дунджаар хэрэглэдэг бүтээгдэхүүний тоо хэмжээнд ижил нөлөө үзүүлдэг.

Бодит үнийг өсгөх нөлөө үзүүлж чадахуйц бодлого нь тамхины хэрэглээг бууруулдаг. “ДЭМБ-ын тамхины татварын гарын авлага” болон “Хорт хавдрын судалгааны олон улсын агентлагийн Хорт хавдрын урьдчилан сэргийлэлтийн гарын авлага: тамхины хяналт, боть 14” зэрэг гарын авлагад иш татсан судалгаануудаас харахад тамхины хэрэглээ болон бодит үнийн хоорондын хамаарал (мэдрэмж) бага, өөрөөр хэлбэл хэрэглээний бууралтын хувь хэмжээ бодит үнийн өсөлтөөс бага байдаг. Энэхүү хамаарлыг үнэтэй холбоотой эрэлтийн мэдрэмж гэсэн ойлголтоор тайлбарладаг. Тухайлбал, үнэтэй холбоотой эрэлтийн мэдрэмжийн утга -0.5 байвал энэ нь “үнэ 10 хувиар нэмэгдэхэд хэрэглээ 5 хувиар буурна” гэсэн үг юм. Тамхин бүтээгдэхүүний хувьд

үнэтэй холбоотой эрэлтийн мэдрэмжийн утга голдуу -0.2-оос -0.8-ын хооронд хэлбэлздэг.

Судалгаануудаас харахад үнэтэй холбоотой эрэлтийн мэдрэмж хугацаа өнгөрөх тусам нэмэгддэг (абсолют утгаар), өөрөөр хэлбэл хугацаа өнгөрөх тусам хэрэглээ улам бүр багасдаг. Орлого багатай иргэд татвар, үнийн өөрчлөлтөд илүү мэдрэг байдаг, учир нь ийм төрлийн өөрчлөлт энэ бүлгийн хүн амын хэрэглээнд илүү хүчтэй нөлөөлдөг байна.

Тамхины хэрэглээний хувьд хүүхэд залуучууд ахимаг насны хүмүүстэй харьцуулахад татвар, үнийн өсөлтөд 2-3 дахин илүү мэдрэг байдаг. Ийм ч учраас тамхины татвар нэмэх нь хүүхэд залуучуудын дунд тамхины хэрэглээ, тархалт, шинээр тамхинд орох, тамхинд донтох явдал буурахад нөлөөлдөг.

Түүнчлэн татвар, үнийг нэмэх нь орлого багатай хүн амын бүлэг болон тамхичид нь үнийн өсөлтөд харьцангуй мэдрэг улс орнуудад тамхины эрэлтийг илүүтэй бууруулж, эрүүл мэндийн тэгш бус байдлыг багасгахад нөлөөлдөг байна.

Татвар нэмснээр төсвийн орлогыг нэмэх боломжтой. Тамхин бүтээгдэхүүний хувьд үнэтэй холбоотой эрэлтийн мэдрэмж бага учраас татварын өсөлт хэрэглээний бууралттай харьцуулахад их байна, өөрөөр хэлбэл татвар нэмсний үр дүнд орлого өсдөг байна.

## **2.2 Татвар ба худалдан авах чадвар (орлоготой холбоотой мэдрэмж)**

Орлого нэмэгдэхэд тамхины хэрэглээ, тархалт нэн ялангуяа бага ба дунд орлоготой улс орнуудад нэмэгддэг. Тамхин бүтээгдэхүүний орлоготой холбоотой эрэлтийн мэдрэмж 0-ээс 1-ийн хооронд хэлбэлздэг. Орлоготой холбоотой эрэлтийн мэдрэмжийн утга 0.5 байвал энэ нь “орлого 10 хувиар нэмэгдэхэд тамхины хэрэглээ 5 хувиар нэмэгдэнэ” гэсэн үг юм.

Орлогын өсөлттэй уялдуулж үнийг нэмэхгүй бол тамхин бүтээгдэхүүн яваандаа илүү боломжийн үнэтэй болно. Худалдан авах чадвар ийнхүү сайжирснаар хэрэглээ нэмэгдэх нь дамжиггүй. Эрдэм шинжилгээний нотолгооноос харахад бага ба дунд орлоготой олон улс оронд тамхин бүтээгдэхүүний үнэ улам бүр боломжийн түвшинд хүрч, худалдан авах чадварын энэхүү өсөлт нь сүүлийн жилүүдэд улам хурдацтай явагдаж байна. Харин орлого ихтэй олон улс оронд татвар, үнийн өсөлт нь орлогын өсөлтөөс их байгаа тул тамхин бүтээгдэхүүнийг худалдан авах чадвар эдгээр улс орнуудад сүүлийн жилүүдэд мууджээ.

Зарим тохиолдолд татварын бодлого нь эмзэг бүлгийн хүн ам (хүүхэд залуучууд, орлого багатай хүн ам)-ын зарим тамхин бүтээгдэхүүнийг худалдан авах чадварыг сайжруулахад чиглэдэг. Энэ нь эрүүл мэндийн тэгш бус байдал, ядуурал гүнзгийрэхэд нөлөөлдөг байна. Худалдан авах чадварыг бууруулахад чиглэсэн татварын бодлого нь эмзэг бүлгийн хүн амын дунд тамхины хэрэглээ илүүтэй буурахад нөлөөлдөг. Учир нь, хүн амын эдгээр бүлгийн дунд үнэтэй холбоотой мэдрэмж өндөр байдаг.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд татварын хэмжээг тогтоохдоо нэмэгдүүлэхдээ инфляц, өрхийн орлогын өөрчлөлт, бусад хүчин зүйлийн зэрэгцээ үнэ болон орлоготой холбоотой эрэлтийн мэдрэмжийн аль алиныг харгалзан, тамхин бүтээгдэхүүнийг худалдан авах чадварыг яваандаа бууруулж, хэрэглээ, тархалтыг нь багасгахад анхаарна. Иймд Оролцогч талууд тамхины татварын бодлогод тогтмол тойм үнэлгээ, тохируулга хийж байх шаардлагатай.

### **3. ТАМХИНЫ ТАТВАРЫН ТОГТОЛЦОО**

#### **3.1 Тамхины татварын бүтэц (өртөгт суурилсан, тусгай, холимог татвар, татварын хамгийн бага түвшин, тамхин бүтээгдэхүүний бусад татвар)**

Засгийн газар өөрийн орны нөхцөл байдал, нийгмийн эрүүл мэндийн, санхүүгийн болон бусад зорилтыг харгалзан тамхины татварын бүтэц, тогтолцооны талаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

Тамхины татварын тогтолцоо нь зөвхөн тусгай татвар, зөвхөн өртөгт суурилсан татвар, эсхүл энэ хоёрын хослол(холимог татвар)-оос бүрдэж болно. Зарим тогтолцоонд бүтээгдэхүүний үнэ буюу бусад шинж чанараас хамаарч татварын хувь хэмжээг ялгавартай тогтоодог(шаталсан татвар). Шаталсан татвар, татварын чөлөөлт бүхий тогтолцоо зэрэг нийлмэл тогтолцоог удирдахад илүү төвөгтэй байдаг ба татвараас чөлөөлөх нь нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх татварын бодлогын нөлөөг сарниулдаг талтай.

##### **3.1.1 Татварын төрөл**

Тамхин бүтээгдэхүүнд тамхины онцгой албан татвар болон тамхин бус бүтээгдэхүүнд ногдуулдаг бусад тусгай татвар(ж.нь, худалдааны татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар(НӨАТ), импортын татвар) ногдуулж болно. Энэхүү удирдамжид тамхины онцгой албан татварын талаар тусгайлан авч үзсэн. Учир нь, энэ нь тамхин бүтээгдэхүүний үнийг бусад бараа, үйлчилгээтэй харьцуулахад илүүтэй нэмэгдүүлэх анхдагч арга болдог байна.

##### **3.1.2 Тусгай онцгой албан татвар**

Тусгай татвар нь нэгдсэн эсхүл шаталсан байж болно. Нэгдсэн тусгай татвар нь үнийн доод хэмжээ (хамгийн бага үнэ)-г тогтоодог. Түүнчлэн энэ төрлийн татвар нь хямд брэндийн хувьд ч гэсэн үнэ өсгөх хандлагатай байдаг.

Нэгдсэн тусгай татвар нь өртөгт суурилсан (ад валорем) татвараас ялгаатай нь хямд болон үнэтэй брэндийн хоорондын үнийн ялгааг багасгадаг тул хэрэглэгчид хямд брэндийн бүтээгдэхүүн хэрэглэх сонирхлыг бууруулж болдог.

Нэгдсэн тусгай татварыг бүтээгдэхүүний өртгөөс бус зөвхөн тоо хэмжээнээс нь хамаарч ногдуулдаг тул харьцангуй хялбар байдаг. Мөн татварын орлого нь бүтээгдэхүүний үнэ биш, харин тоо хэмжээнээс хамаардаг тул нэгдсэн тусгай татварын орлогыг урьдчилан тооцоход хялбар, илүү тогтвортой, үйлдвэрлэгчийн үнийн бодлогоос хамаарал багатай байдаг. Гэхдээ татварын хувь хэмжээг ядаж инфляцтай уялдуулан үе үе нэмж байхгүй бол татварын бодит хэмжээ хэт бага болох эрсдэлтэй.

##### **3.1.3 Өртөгт суурилсан (ад валорем) онцгой албан татвар**

Өртөгт суурилсан(ад валорем) татварыг жижиглэн худалдааны үнэ (холбогдох бүх татварыг оруулсан), үйлдвэрлэгчийн үнэ, эсхүл өртөг, даатгал болон тээврийн зардал зэрэг тодорхой суурь өртгийн хувь хэмжээгээр илэрхийлдэг. Нэгдсэн тусгай татвартай харьцуулахад өртөгт суурилсан татвар нь хямд болон үнэтэй брэндийн хоорондын үнийн ялгааг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд хямд брэндийг сонгох сонирхлыг бий болгодог. Өртөгт суурилсан татварыг дангаар нь ногдуулбал үнийн өрсөлдөөн нэмэгдэж, дундаж үнэ буурахад хүргэж болзошгүй.

Өртөгт суурилсан татварыг бүтээгдэхүүний өртөг, тоо хэмжээний аль алинаас нь хамаарч ногдуулдаг тул харьцангуй төвөгтэй байдаг. Өртөгт



суурилсан татварыг дангаар нь ногдуулбал, нэн ялангуяа үйлдвэрлэгчийн үнэ эсхүл өртөг, даатгал болон тээврийн зардлыг татварын суурь болгон ашигласан тохиолдолд бүтээгдэхүүний үнэлгээг багаар тогтоож, татвар ногдуулах өртгийг бууруулахад хүргэж болзошгүй. Харин татварын доод хэмжээг тогтоосноор бүтээгдэхүүний үнэлгээг багаар тогтоохоос сэргийлж болно. Ийнхүү татварын доод хэмжээг тогтоох нь жижиглэн худалдааны үнээс нь үл хамаарч бүх брэндэд онцгой албан татварыг ядаж доод хэмжээгээр нь ногдуулах боломж олгодог байна.

Өртөгт суурилсан татварын орлого нь бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн аль алинаас хамаардаг тул татварын орлогыг урьдчилан тооцоход төвөгтэй, тогтвортой биш, үйлдвэрлэгчийн үнийн стратегиас илүү хамаардаг. Инфляцийг дагаж үнэ өсдөг тул өртөгт суурилсан татварын бодит хэмжээ буурдаггүй давуу талтай.

### **3.1.4 Холимог тусгай болон өртөгт суурилсан онцгой албан татвар**

Тусгай болон өртөгт суурилсан онцгой албан татварын аль аль нь холимог онцгой албан татварын бүрэлдэхүүн хэсэг байж болно. Холимог татвар нь голдуу нэгдсэн тусгай татвар(энэ нь харьцангуй хямд брэндэд илүү нөлөөлдөг) болон өртөгт суурилсан татвар (энэ нь харьцангуй үнэтэй брэндэд илүү нөлөөлдөг)-ыг нэгтгэсэн байдаг. Холимог татварын тогтолцоонд өртөгт суурилсан татвар, тусгай татварын аль нь илүү ач холбогдолтой байх нь тухайн улсын нөхцөл байдал, бодлогын зорилтоос хамаардаг. Өртөгт суурилсан татвар нь брэндүүдийн хоорондын үнийн ялгааг нэмэгдүүлж, хямд брэндийн хэрэглээг дэмждэг тул нийгмийн эрүүл мэндийн зорилтод тэр бүр нийцдэггүй. Харин тусгай татвар нь хямд болон үнэтэй брэндүүдийн хоорондын үнийн ялгааг багасгадаг байна.

Холимог татвар нь тусгай болон өртөгт суурилсан татварын давуу талуудыг нэгтгэхийг зорьдог. Холимог татварыг бүтээгдэхүүний өртөг, тоо хэмжээний аль алинаас нь хамаарч ногдуулдаг тул нэгдсэн тусгай татвартай харьцуулахад харьцангуй төвөгтэй байдаг.

Холимог татварын тогтолцоонд бүтээгдэхүүний үнэлгээг багаар тогтоох эрсдэл цэвэр өртөгт суурилсан татвартай харьцуулахад бага байна. Энэхүү эрсдэлийг улам бууруулахын тулд татварын доод хэмжээг тогтоож болно. Ийнхүү татварын доод хэмжээг тогтоох нь жижиглэн худалдааны үнээс нь үл хамаарч бүх брэндэд онцгой албан татварыг ядаж доод хэмжээгээр нь ногдуулах боломж олгодог байна.

Холимог татварын орлого нь бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн аль алинаас хамаардаг тул цэвэр тусгай татвартай харьцуулахад татварын орлогыг урьдчилан тооцоход төвөгтэй, тогтвортой биш, үйлдвэрлэгчийн үнийн стратегиас илүү хамаардаг. Гэхдээ инфляцийн нөлөөгөөр татварын бодит хэмжээ буурах эрсдэл цэвэр тусгай татвартай харьцуулахад бага юм.

### **3.1.5 Тамхин бүтээгдэхүүнд ноогдуулах бусад татвар**

Тамхин бүтээгдэхүүнд тусгайлан ногдуулдаг бусад татвар (ж.нь, худалдааны татвар, НӨАТ)-ын асуудлыг энэхүү удирдамжид авч үзээгүй болно. Ийм төрлийн татвар нь тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдааны үнэд нөлөөлдөг ч тамхин бүтээгдэхүүний бусад бараа, бүтээгдэхүүнтэй харьцуулсан үнэд нөлөөлдөггүй тул нийгмийн эрүүл мэндэд ач холбогдол харьцангуй багатай.

Зарим улсад тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулдаггүй, зөвхөн импортын татвар зэрэг бусад татвар ногдуулдаг байна. Эдгээр улсад

үнийн болон татварын бодлогоор тамхины хэрэглээг үр дүнтэй бууруулахын тулд тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварыг нэвтрүүлэх шаардлагатай.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд өөрийн орны нөхцөл байдлыг харгалзан нийгмийн эрүүл мэндийн болон санхүүгийн хэрэгцээндээ нийцсэн хамгийн энгийн, үр ашигтай татварын тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай. Оролцогч талууд татварын доод хэмжээ бүхий тусгай эсхүл холимог онцгой албан татвар ногдуулах нь дан өртөгт суурилсан татвараас давуу талтай.

### **3.2 Ногдуулах татварын хувь хэмжээ**

Үндсэн зарчим 1.1-д заасанчлан Оролцогч талууд өөрийн татварын бодлого, үүнд ногдуулах татварын хувь хэмжээ тодорхойлох, тогтоох бүрэн эрхтэй. Улс орнуудын татварын тогтолцоо, газарзүйн болон эдийн засгийн нөхцөл байдал нийгмийн эрүүл мэндийн болон санхүүгийн зорилтууд нь ялгаатай тул тамхины татварын бүх улсад тохиромжтой хувь хэмжээ гэж байдаггүй. Тамхины татварын хувь хэмжээг тогтоохдоо татварын абсолют хувь хэмжээнээс илүүтэй жижиглэн худалдааны үнийг харгалзан үзэх шаардлагатай. Ийм ч учраас ДЭМБ-аас тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдааны үнэд онцгой албан татварын эзлэх хувь хэмжээтэй холбоотой зөвлөмж өгсөн байна.

Жижиглэн худалдааны үнэд татварын эзлэх хувийг үр дүнтэй тооцоолохын тулд “жинлэсэн дундаж үнэ”-ийн үзэл баримтлалыг ашиглах нь зүйтэй.

Улс орнууд нийгмийн эрүүл мэндийн, санхүүгийн болон бусад зорилтоо хэрэгжүүлэхийн тулд тамхины татварын урт хугацааны бодлоготой байвал зохино. Ингэхдээ тамхины татварын хувь хэмжээг тогтмол хянаж, тамхин бүтээгдэхүүнийг худалдан авах чадварыг харгалзан (2.2 дугаар хэсгээс харна уу) тохируулга хийж байх шаардлагатай.

Тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдааны үнэд татварын эзлэх хувь хэмжээ улс орнуудад асар ялгаатай байдаг. Бүс нутгийн хэмжээнд буюу хөрш зэргэлдээ орнуудын хооронд татвар болон үнийн зөрүү их байх нь бүтээгдэхүүнийг орлуулах, хил дамнасан худалдаа эрхлэх, шаглах явдлыг хөхиүлэн дэмждэг тул тамхин бүтээгдэхүүний үнэ харьцангуй багатай улс орнууд татвараа нэмж, ийм төрлийн хөшүүргийг багасгах нь зүйтэй.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд нийгмийн эрүүл мэндийн болон санхүүгийн зорилтуудаа тодорхой хугацаанд хэрэгжүүлэхийн тулд тамхины татварын урт хугацааны бодлого, үүнд татварын хувь хэмжээтэй холбоотой зорилтоо тодорхойлж, хэрэгжилтийг нь тогтмол үнэлэх шаардлагатай.

Тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бууруулахын тулд инфляц, орлогын өсөлтийг харгалзан татварын хувь хэмжээг тогтмол, боломжтой бол жил тутам хянаж, тохируулга хийнэ.

### **3.3 Өөр өөр тамхин бүтээгдэхүүнд татварыг ижил төстэй байдлаар ногдуулах**

Дэлхийн өнцөг булан бүрт хэрэглэдэг тамхин бүтээгдэхүүний маш олон төрөл бий. Оролцогч талууд үйлдвэрлэсэн янжуур тамхины татварын бодлогод

түлхүү анхаарч ирсэн боловч бүх тамхин бүтээгдэхүүнийг хамарсан татварын бодлого чухал болохыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Түүнчлэн өөр өөр бүтээгдэхүүнд татвар ногдуулах зорилго нь ижил байх тул татварын тогтолцоог хялбаршуулж, хооронд нь уялдуулах нь зүйтэй.

Тамхин бүтээгдэхүүний татварыг нэмснээс үнэ нь өсөхөд зарим хэрэглэгчид арай хямд брэндийн бүтээгдэхүүн хэрэглэж эхэлдэг. Улмаар татвар нэмсэнтэй холбоотой тамхин бүтээгдэхүүний хэрэглээний бууралт саармагждаг.

Түүнчлэн тамхин бүтээгдэхүүний өөр өөр төрөл (ж.нь, үйлдвэрлэсэн янжуур тамхи, өөрөө ороож татдаг дүнсэн тамхи)-д татварыг ялгавартайгаар тогтоох, ижил төрлийн бүтээгдэхүүн (ж.нь, харьцангуй хямд ба үнэтэй янжуур тамхи)-д татварыг ялгавартайгаар ногдуулах нь зарим хэрэглэгчид арай хямд брэндийн бүтээгдэхүүн хэрэглэж эхлэх хөшүүрэг болдог.

### **Зөвлөмж**

Нэг төрлийн бүтээгдэхүүнийг нөгөөгөөр орлуулах эрсдэл байгаа нөхцөлд бүх тамхин бүтээгдэхүүнд аль болох ижил төстэй байдлаар татвар ногдуулах шаардлагатай.

Хэрэглэгчид татвар буюу жижиглэн худалдааны үнийн өсөлт, зах зээлийн бусад өөрчлөлтийн нөлөөгөөр ижил төрлийн эсхүл өөр төрлийн арай хямд бүтээгдэхүүн хэрэглэж эхлэх хөшүүргийг багасгах байдлаар татварын бодлогоо тодорхойлоход Оролцогч талууд анхаарах ёстой.

Иймд бүх тамхинд бүтээгдэхүүнд ногдуулах татварын хувь хэмжээг тогтмол үнэлж, шаардлагатай бол нэмж, аль болох ижил төстэй байлгахыг эрмэлзэнэ.

## **4. ТАТВАР НОГДУУЛАЛТ**

### **4.1 Тусгай зөвшөөрөл**

Тамхины нийлүүлэлтийн сүлжээг хянах нь татвар ногдуулалтыг үр дүнтэй, үр ашигтай байлгахад чухал ач холбогдолтой.

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах протоколын 6 дугаар зүйлд заасанчлан нийлүүлэлтийн сүлжээг хянахын тулд тусгай зөвшөөрөл олгох болон түүнтэй төстэй зөвшөөрөл, хяналтын тогтолцоо нэвтрүүлэх нь зүйтэй.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд тусгай зөвшөөрөл олгох болон түүнтэй төстэй зөвшөөрөл, хяналтын ил тод тогтолцоо бүрдүүлнэ.

### **4.2 Агуулахын тогтолцоо/онцгой албан татвар ногдуулдаг бараа бүтээгдэхүүний хөдөлгөөн ба татвар төлөлт**

Татварын өрийг барагдуулахын тулд үйлдвэрлэл, агуулахын барилга байгууламжид хяналт тавих, үүний тулд эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан агуулахын сүлжээ байгуулах шаардлагатай. Цөөнгүй улс оронд онцгой албан татвар ногдуулдаг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, хүлээн авах, түгээх үүргийг хувь хүн, хуулийн этгээд (агуулах зэрэг)-д ногдуулдаг. Эдгээрээс татвар төлөх баталгаа гаргаж өгөхийг шаардаж болно. Энэхүү тогтолцоог хэрэгжүүлэхийн тулд тусгай зөвшөөрөл олгох нарийн шалгуур тогтоох, агуулахад тусгай зөвшөөрөл олгох үзлэг хийх,

агуулахын бараа хянах арга хэмжээ хэрэгжүүлэх, бараа бүтээгдэхүүний гарал үүсэл болон үйлдвэрлэлийн үйл явцыг хянах, бүтээгдэхүүнийг кодлох, тэмдэглэгээ хийх шаардлагатай. Онцгой албан татвар ногдуулдаг бараа бүтээгдэхүүний хөдөлгөөнийг хянах компьютерийн систем ашиглаж болно.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварын хяналтыг хөнгөвчлөх үйлдвэрлэл, хадгалалтын агуулахын арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Татвар хураах үйл ажиллагааг хялбарчлах үүднээс онцгой албан татварыг үйлдвэрлэл, импортын цэг эсхүл үйлдвэрлэл, хадгалалтын агуулахаас хэрэглээнд зориулж гаргах шатанд ногдуулна.

Хуулинд татвар төлөлтийг тогтсон хугацаанд буюу сар бүрийн тодорхой өдөр хийхээр зааж, ингэхдээ боломжтой бол үйлдвэрлэл ба/буюу борлуулалтын хэмжээ, үнийг брэнд тус бүрээр, төлбөл зохих ба төлсөн татварын хэмжээ, түүхий эдийн орц хэмжээ зэргийг тайлагнахыг шаардах нь зүйтэй.

Татварын байгууллага нууцлалтай холбоотой хууль тогтоомжид нийцүүлэн дээрх мэдээллийг онлайн болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлнэ.

### **4.3 Татвар нэмэхээс өрсөж бараа нөөцлөхөөс сэргийлэх**

Зарим тохиолдолд үйлдвэрлэгч буюу импортлогчид татвар нэмэх гэж байгааг урьдчилан мэдэж болно. Энэ нь инфляцийн түвшингийн өөрчлөлт буюу бусад шалгууртай уялдуулж татвар нэмдэг тогтолцоонд нэн ялангуяа хамааралтай байдаг. Ийм тохиолдолд үйлдвэрлэгчид буюу импортлогчид татвар нэмэхээс өрсөж татвар бага байгаа дээр үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, бараа нөөцлөх оролдлого хийж болдог.

Үүнээс сэргийлэхийн тулд Оролцогч талууд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Татвар нэмэхийн өмнөхөн тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг эрс нэмэгдүүлэхийг хязгаарлах;
- Үйлдвэрлэж, хадгалж байгаа боловч хэрэглэгчид борлуулахаар худалдаанд гаргаагүй байгаа бүтээгдэхүүнд шинээр нэмэгдүүлсэн хувь хэмжээгээр татвар ногдуулах.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд үйлдвэрлэгчид буюу импортлогчдын татвар нэмэхээс өрсөж бараа нөөцлөх оролдлогыг хязгаарлах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

### **4.4 Татварын тэмдэг**

Үйлдвэрлэл, импортыг хянах замаар Татварын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах нэг арга нь татварын тусгай тэмдэг ашиглах явдал юм. Татварын тэмдэг нь хууль бус тамхин бүтээгдэхүүнийг илрүүлэхэд ач холбогдолтой. Татварын тэмдэг нь энгийн, сайжруулсан (туузан үнэт цаасан наалт), дижитал байж болно. Татварын тэмдгийг бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын тогтсон хэсэгт байрлуулна. Сав, баглаа, боодолд стандарт хэмжээ дот тогтоох нь татварын тэмдэг тавих боломжийг хялбаршуулдаг.

ДЭМБ-ын ТХСК-ийн 15 дугаар зүйлийн дагуу тамхин бүтээгдэхүүнд дахин давтагдашгүй дугаар бүхий тэмдэг тавих зэрэг хяналтын системийг нэвтрүүлэх нь түгээлтийн тогтолцооны аюулгүй байдлыг хангаж, хууль бус худалдааг таслан зогсооход тус дөхөм болдог.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд Татварын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор татварын тэмдэг хэрэглэх шаардлага тавих нь зүйтэй.

## **4.5 Хяналт**

Тамхины татварын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хяналт тавих эрх бүхий байгууллагыг тохоон томилох шаардлагатай. Татварын байгууллагууд хууль хяналтын байгууллагын нэгэн адил шалгалт хийх, бараа бүтээгдэхүүнийг битүүмжлэх, хураах, устгах эрх мэдэл, чадавх, технологитой байх нь зүйтэй. Хяналт тавих эрх бүхий байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үр ашигтай арга зам мөн.

Татварын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл шинээр олгоход илүү хатуу шаардлага тавих, торгууль ногдуулах, хорих, бүтээгдэхүүнийг хураах, бүтээгдэхүүний үйлдвэрлэл буюу түгээлтэд түгээлтэд ашигласан тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг хураах, татан буулгах, захиргааны бусад шийтгэл ногдуулах арга хэмжээ авч болно. Татварыг хугацаанд нь төлөөгүй нөхцөлд торгууль, хүү ногдуулж, татвараас зайлсхийсэн тохиолдолд татвар нөхөн ногдуулах, цээрлүүлэх татвар ногдуулах арга хэмжээ авна.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд татварын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагыг томилж, зохих эрх мэдлийг олгох шаардлагатай.

Оролцогч талууд хууль хяналтын байгууллагуудад хуульд нийцүүлэн хоорондоо мэдээлэл солилцох боломжийг олгоно.

Оролцогч талууд хууль тогтоомжийн зөрчлөөс сэргийлэхийн тулд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг зохистой байдлаар тогтооно.

## **5. ОРЛОГЫГ ТАМХИНЫ ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХЭД АШИГЛАХ НЬ**

ДЭМБ-ын ТХСК-ийн 6.2 дугаар зүйлд заасанчлан Оролцогч талууд татварын бодлогоо тодорхойлох, тогтоох бүрэн эрхтэй байна. Оролцогч талууд энэхүү бүрэн эрхийнхээ хүрээнд тамхины татварын орлогыг хэрхэн ашиглахыг өөрсдөө шийдэх эрхтэй.

ТХСК-ийн 8, 9, 10, 12 ба 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид өгүүлсэнчлэн тамхины онцгой албан татвар нь тамхины хяналтын арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр болдог.

Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 26.2 дугаар зүйл, үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн татварын орлогоос тамхины хяналтын хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой. Зарим Оролцогч талууд тамхины татвараас олсон

орлогоор тамхины хяналтын хөтөлбөрийг санхүүжүүлдэг бол зарим нь санхүүжүүлдэггүй.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 26.2 дугаар зүйл, үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, тамхинаас гарах үйлчилгээ үзүүлэх, амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэх тамхи тариалахаас бусад үйл ажиллагаа эрхлэх боломжоор хангах, тамхины хяналтын зохих бүтцүүдийг санхүүжүүлэх зэргээр тамхины хяналтын хөтөлбөрийг татварын орлогоос санхүүжүүлэх нь зүйтэй.

## **6. ТАТВАРГҮЙ ХУДАЛДАА**

Нисэх буудал, олон улсын тээврийн хэрэгсэл, татваргүй худалдааны байгууллага зэрэгт тамхин бүтээгдэхүүнийг онцгой албан татвар ногдуулахгүйгээр борлуулдаг. Нисэх буудал болон бусад тусгайлан заасан цэгүүдэд явуулж буй татваргүй худалдаа нь зөвхөн зорчигчдод зориулагдсан бөгөөд тэд худалдан авсан тамхин бүтээгдэхүүнээ тухайн улсын нутаг дэвсгэрээс авч гарах тул орон нутгийн буюу үндэсний зарим төрлийн татвараас чөлөөлөгддөг байна. Гэхдээ зарим улсад зорчигчид тухайн улсаас явахдаа төдийгүй тухайн улсад нэвтрэхдээ нисэх буудлын татваргүй худалдааны дэлгүүрээс худалдан авалт хийж болдог.

Татвараас чөлөөлсөн тамхин бүтээгдэхүүн нь харьцангуй хямд байдаг тул татваргүй худалдаа нь тамхин бүтээгдэхүүний эрэлтийг бууруулах татвар болон үнийн арга хэмжээний нөлөөг сулруулдаг. Энэ нь татварын бодлогын эрүүл мэндийн үр нөлөөг саармагжуулж, хэрэглээг өөгшүүлэх замаар нийгмийн эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг. Түүнчлэн татваргүй бараа бүтээгдэхүүн нь хууль бус худалдааны эх сурвалж болж, татварын бүтцэд “цоорхой” үүсгэж, төсвийн орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Ийм ч учраас засгийн газрын зүгээс татваргүй худалдааг хязгаарлах, хориглох арга хэмжээ авах нь нэмэгдэж байна.

Татваргүй худалдааг хориглох олон улсын хүчин чармайлт нь дараах гурван хувилбартай байна. Үүнд:

- Тамхин бүтээгдэхүүний татваргүй худалдааг хориглох;
- Татваргүй худалдааны дэлгүүрт борлуулж буй тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах;
- Хувь хүн татваргүй тамхин бүтээгдэхүүн импортлохыг хязгаарлахын тулд нэг зорчигчийн худалдан авч болох татваргүй тамхин бүтээгдэхүүний тоо хэмжээнд хязгаарлалт тогтоох.

### **Зөвлөмж**

Оролцогч талууд олон улсын зорчигчдын татваргүй тамхин бүтээгдэхүүн худалдан авах, импортлох боломжийг хязгаарлах, хориглох арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй.

## **7. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Шинжлэх ухааны болон хууль эрх зүйн салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, энэ чиглэлээр туршлага, мэдлэг, мэдээлэл солилцох нь

Оролцогч талуудын ДЭМБ-ын ТХСК-ийн 6 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх чухал арга зам юм. Энэ нь Оролцогч талуудын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар ДЭМБ-ын ТХСК-ийн 4.3, 5.4, 5.5, 20, 22 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэгтэй нийцсэн байвал зохино.

Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 21 дүгээр зүйлд заасанчлан конвенцийн хэрэгжилтийн талаар тогтмол тайлагнах нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх бас нэг чухал арга зам юм. Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 21 дүгээр зүйлд заасан ёсоор конвенцийн хэрэгжилтийг тайлагнахдаа тамхин бүтээгдэхүүнд ногдуулж буй татварын хувь хэмжээ, тамхины хэрэглээний хандлагын талаар тоо мэдээ ирүүлэх ёстой гэж ТХСК-ийн 6 дугаар зүйлд заасан байна. Ингэхдээ татварын абсолют Тоо хэмжээнээс гадна борлуулалтын үнэд татварын эзлэх хувь хэмжээг тайлагнах нь зүйтэй.

Олон улсын хамтын ажиллагааны ачаар татвар, үнийн бодлоготой холбоотой үнэн зөв мэдээ, туршлагыг дэлхийн, бүс нутгийн, үндэсний түвшинд нэн ялангуяа Конвенцийн нарийн бичгийн даргын газраас хариуцдаг конвенцийн хэрэгжилтийн дэлхийн мэдээний сангаар дамжуулан солилцох боломжтой болдог. Тогтмол хуралддаг Оролцогч талуудын Бага хурлын үеэр Оролцогч талууд нэг нэгнийхээ тайлан, дэлхийн ахиц дэвшлийн тайлангийн тоо мэдээтэй танилцаж, татвар, үнийн бодлогын талаарх олон улсын туршлагатай холбоотой мэдлэгээ дээшлүүлэх боломжтой.

Оролцогч талууд хоёр ба олон талт хамтын ажиллагааны механизм, байгууллагуудаар дамжуулж татвар, үнийн бодлоготой холбоотой хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой.

Оролцогч талууд энэхүү удирдамж тамхин бүтээгдэхүүний татвар, үнийн бодлогоо тодорхойлоход нь дөхөм болж чадаж байгаа эсэхийг Оролцогч талуудын Бага хурлаас тогтоосон хугацаанд нийцүүлэн тоймлон үнэлж, шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр хамтран ажиллана.

## 8. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

*Үнэ ба татварын бодлого (Конвенцийн 6 дугаар зүйл): ДЭМБ-ын тамхигүй санаачилгаас гаргасан тайлан.* Оролцогч талуудын Бага хурлын дөрөвдүгээр хуралдаанд зориулсан тайлан, Пунта дель Эсте, Уругвай, 2010 (баримт бичиг FCTC/COP/4/11). Вэбсайт: [https://apps.who.int/gb/fctc/PDF/cop4/FCTC\\_COP4\\_DIV6-en.pdf](https://apps.who.int/gb/fctc/PDF/cop4/FCTC_COP4_DIV6-en.pdf)

*Тамхины хяналтад татвар, үнийн бодлогын үзүүлэх нөлөө* (Хорт хавдрын судалгааны олон улсын агентлагийн Хорт хавдрын урьдчилан сэргийлэлтийн гарын авлага: тамхины хяналт, боть 14). Лион, Хорт хавдрын судалгааны олон улсын агентлаг, 2011.

*ДЭМБ-ын тамхины татварын гарын авлага.* Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2010.

*Тахлыг зогсоох нь: Засгийн газар ба тамхины хяналтын эдийн засаг,* Вашингтон, Колумбийн тойрог, Дэлхийн банк, 1999.